



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 487

Мандалговь

Г Арга хэмжээ зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.1, 4.4.1, 7.5, Хог хаягдалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.6 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын нэгдүгээр бүс буюу Нарлаг багт орон сууц, худалдаа, үйлчилгээний газар, нийтийн эзэмшлийн зам талбай орчимд нүхэн жорлон шинээр байгуулахыг хориглосугай.

2. Хотын төв буюу нэгдүгээр бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага болон айл өрхийн нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах ажлыг зохион байгуулсугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Хот тохижуулах газрын дарга (Д.Мөнхцоож), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн), Нарлаг багийн засаг дарга (Г.Буянбат) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Баярсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГОХ

